

**ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ
СҮЛЖЭЭ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ
КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2020 оны 11 сарын 16 өдөр

Дугаар А/193

Улаанбаатар хот

**Шугам, тоноглолын найдвартай ажиллагааг хангаж,
хариуцлагатай жижүүр томилон ажиллуулах тухай**

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх заалт, “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн дүрэм”-ийн 10 дугаар зүйлийн 10.11.10 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 15-ны ээлжит бус өргөтгөсөн хурал, Эрчим хүчний сайдын 2020 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх хөл хорионы үед буюу 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрөөс 12 дугаар сарын 01-ний өдрүүдэд компанийн төв удирдлагын ажлын байранд ажиллах хариуцлагатай жижүүрийн хуваарийг нэгдүгээр хавсралт ёсоор, ажиллах удирдамжийг хоёрдугаар хавсралт ёсоор баталсугай.

2. Эрчим хүчний яамнаас ирүүлсэн батлагдсан маягт, хүснэгтийн дагуу судалгаа мэдээллүүдийг гүйцэтгэх захирал /Б.Нямсамбуу/, тэргүүн дэд захирал бөгөөд ерөнхий инженер /Б.Дашдаваа/ нарт цаг алдалгүй өгч мэдээлж ажиллахыг хэлтсийн дарга, салбарын удирдлага, хариуцлагатай жижүүрүүдэд үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан салбарын хариуцлагатай жижүүрээр ажиллах ажилтнуудын хуваарь, удирдамжийг тушаалаар баталгаажуулан мөрдөж ажиллахыг Улаанбаатар салбарын дарга /Ч.Мөнхпүрэв/, Төвийн бүсийн салбарын дарга /Ж.Мөнхжаргал/, Хангайн бүсийн салбарын дарга /П.Баясгалан/, Зүүн-Өмнөд бүсийн салбарын дарга /Н.Мөнгөнхөлөгт/, Говийн бүсийн салбарын дарга /С.Намжилцэрэн/ нарт тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллах, тайланг нэгтгэж, 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдөр компанийн удирдлагад танилцуулахыг Хяналт мониторингийн хэлтсийн дарга /Я.Мөнхтөр/-д даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.НЯМСАМБУУ

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ
ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2020 оны
11 дүгээр сарын 16 ны өдрийн А/193
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт




ХАРИУЦЛАГАТАЙ ЖИЖҮҮРИЙН АЖИЛЛАХ ХУВААРЬ

№	Жижүүрийн ажиллах цагийн хуваарь	Жижүүрээр ажиллах албан тушаалтан, жолооч нарын нэрс	Холбогдох утасны дугаар
1	2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 08:00 цагаас 18-ны өдрийн 08:00 цаг хүртэл	ТХХ-ийн дарга Э.Бат-Орших НҮТМХ-ийн жолооч Б.Бат-Очир	9919-0587 9903-7980
2	2020 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 08:00 цагаас 19-ний 08:00 цагт хүртэл	РХАХТХ-ийн дарга Н.Батбаяр НҮТМХ-ийн жолооч М.Батзориг	9902-1786 8887-3362
3	2020 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 08:00 цагаас 20-ны өдрийн 08:00 цагт хүртэл	МТХ-ийн дарга Ч.Нэргүй НҮТМХ-ийн жолооч Б.Арслан	9910-5567 8080-8848
4	2020 оны 11 дүгээр сарын 20-ны 08:00 цагаас 21-ний 09:00 цаг хүртэл	ТХХ-ийн Засварын инженер Э.Батбаяр НҮТМХ-ийн жолооч П.Отгонбаатар	9905-7928 9906-3342
5	2020 оны 11 дүгээр сарын 21-ний 09:00 цагаас 22-ны 09:00 цаг хүртэл	ХМХ-ийн дарга Я.Мөнхтөр НҮТМХ-ийн жолооч Ж.Батцэнгэл	9908-2824 9919-9921
6	2020 оны 11 дүгээр сарын 22-ны 09:00 цагаас 23-ны 08:00 цаг хүртэл	ТБТХ-ийн дарга Д.Чинбат НҮТМХ-ийн жолооч Ф.Ганболд	9911-6256 9916-8334
7	2020 оны 11 дүгээр сарын 23-ны 08:00 цагаас 24-ний 08:00 цаг хүртэл	ШЗХ-ийн дарга М.Өмербай НҮТМХ-ийн жолооч Б.Бат-Оргил	9903-6972 9902-7158
8	2020 оны 11 дүгээр сарын 24-ний 08:00 цагаас 25-ны 08:00 цаг хүртэл	ШЗХ-ийн ахлах диспетчер инженер Ж.Чинзаяа НҮТМХ-ийн жолооч О.Бямбасүрэн	9909-5948 9901-5966
9	2020 оны 11 дүгээр сарын 25-ны 08:00 цагаас 26-ны 09:00 цаг хүртэл	ТБТХ-ийн ахлах бөгөөд ашиглалтын инженер Б.Энхбат НҮТМХ-ийн жолооч Д.Батбаяр	9904-5258 9963-5053

10	2020 оны 11 дүгээр сарын 26-ны 09:00 цагаас 27-ны 08:00 цаг хүртэл	РХАХТХ-ийн ахлах бөгөөд РХ-ын инженер З.Батзориг НҮТМХ-ийн жолооч Ц.Гансүх	9907-7922 9905-4756
11	2020 оны 11 дүгээр сарын 27-ны 08:00 цагаас 28-ны 09:00 цаг хүртэл	ХМХ-ийн ахлах бөгөөд Техник хяналтын инженер Д.Мөнхзаяа НҮТМХ-ийн жолооч Б.Бат-Очир	9907-3998 9903-7980
12	2020 оны 11 дүгээр сарын 28-ны 09:00 цагаас 29-ний 09:00 цаг хүртэл	ХМХ-ийн Техник хяналтын инженер Н.Эрдэнэжаргал НҮТМХ-ийн жолооч М.Батзориг	8004-2009 8887-3362
13	2020 оны 11 дүгээр сарын 29-ний 09:00 цагаас 30-ны 08:00 цаг хүртэл	ТБТХ-ийн Техник шинэчлэл хариуцсан инженер П.Ариунболд НҮТМХ-ийн жолооч Б.Арслан	9906-3775 8080-8848
14	2020 оны 11 дүгээр сарын 30-ны 08:00 цагаас 12 дугаар сарын 01-ний 08:00 цаг хүртэл	ХМХ-ийн ХАБЭА-н инженер Б.Батчулуун НҮТМХ-ийн жолооч П.Отгонбаатар	9907-8217 9906-3342

ХЯНАЛТ МОНИТОРИНГИЙН ХЭЛТЭС



Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ
ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2020 оны
11 дүгээр сарын 16 ны өдрийн 11/16
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ХАРИУЦЛАГАТАЙ ЖИЖҮҮРИЙН АЖЛЫН УДИРДАМЖ

Нэг. Зорилго:

1.1 Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх хөл хорионы өдөр дамжуулах сүлжээний шугам, тоноглол дэд станцуудын үйл ажиллагааны найдвартай, тасралтгүй байдалд хяналт тавьж, аваар саатал, гэмтэл, зөрчлийг цаг тухайд нь арилгах ажлыг шуурхай зохион байгуулж, хэвийн горим ажиллагаанд оруулах, дэд станцуудын ээлжийн инженер техникийн ажилтнуудын сонор сэрэмжийг дээшлүүлэх, гамшиг, гал түймрийн аюулгүй байдлыг хангах, Эрчим хүчний яам болон компанийн удирдлагуудыг мэдээллээр хангахад оршино.

Хоёр. Хариуцлагатай жижүүрийн ажлын чиглэл

2.1 Хариуцлагатай жижүүрүүд, жолооч нар 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 08:00 цагаас 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 08:00 цаг хүртэл хугацаанд хариуцлагатай жижүүрийн хуваарийн дагуу ажиллана.

2.2 Цахилгаан тоног төхөөрөмжид гарсан саатал, гэмтэл зөрчлийг арилгах ажлыг шуурхай зохион байгуулж гүйцэтгэлд нь хяналт тавина.

2.3 Компанийн болон салбарын диспетчер инженер, дэд станцын ээлжийн ажилтнуудын ажиллагаанд хяналт тавьж дэд станц ажлын байраар гэнэтийн эргүүл үзлэг хийнэ.

2.4 Ажиллагаатай холбоотой мэдээллийг салбаруудад ажиллаж байгаа жижүүрүүдээс авч нэгтгэж, компанийн удирдлагад тогтмол мэдээллэнэ.

2.5 Эргүүл үзлэгээр илэрсэн зөрчлийг арилгуулах ажлыг зохион байгуулна.

2.6 Тухайн өдрийн компанийн технологийн үйл ажиллагааны талаар тусгай журналд тэмдэглэл хөтөлнө.

2.7 Дэд станц, ажлын байруудад галын аюулгүй байдлыг хангах зорилгоор гал унтраах анхан шатны багаж хэрэгслүүдийн бэлэн байдал, цахилгаан хэрэгслүүдийн галын аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх үзлэгийг хийлгүүлэх, илэрсэн зөрчлийг арилгуулах, холбогдох мэдээллийг тэмдэглэж бүртгэнэ.

2.8 Ажилтнуудын биеийн байдлыг хянаж, халууныг хэмжих хүснэгтийг бөглөж 2 цаг тутамд удирдлагад мэдээлэх

2.9 Цаг ашиглалт, гэрээс ажиллаж байгаа ажилтнуудын шилжилт хөдөлгөөн, албаны болон хувийн тээврийн хэрэгслийн маршрутад хяналт тавих

2.10 Оффист болон гэрээр ажиллаж байгаа болон ээлжийн ажилчдын ирцийн мэдээлэл, ээлж хэвийн солигдсон эсэх мэдээллийг ирүүлэх

2.11 Салбаруудын хариуцлагатай жижүүрүүд төв компанийн хариуцлагатай жижүүрт ЭХЯ-аас батлагдан ирүүлсэн судалгааны хүснэгтийг бөглөж, тогтмол мэдээллээр хангах

2.12 Компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг ЭХЯ болон холбогдох дээд шатны байгууллагуудад цаг тухай бүрт нь мэдээлж ажиллана.

ХЯНАЛТ МОНИТОРИНГИЙН ХЭЛТЭС